

**АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ,  
УЛСЫН ДУГААР ОЛГОХ ЖУРАМ**

**НЭГ. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсад ашиглагдаж байгаа автотээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших эрх болон ашиглалттай холбоотой бүртгэл хөтлөх, тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн сан байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасны дагуу гүйцэтгэх ажлын зориулалтаар ашиглаж байгаа автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх үйл ажиллагаа энэхүү журамд хамаарахгүй.

1.3. Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх үйл ажиллагааг Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгогдсон бүртгэлийн байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

**ХОЁР. Журмын нэр томьёоны тодорхойлт**

2.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “автотээврийн хэрэгсэл” гэж Автотээврийн тухай хуулийн 3.1.1.-д заасныг болон бүх төрлийн дугуйт механизм, мотоциклийг хамруулан ойлгоно;

2.1.2. “бүртгэлийн байгууллага” гэж энэ журмын 1.3-т заасан байгууллага;

2.1.3. “бүртгэл хөтлөх” гэж автотээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгүүлэх мэдүүлэг, нотлох баримтыг үндэслэн тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санд мэдээллийг оруулах үйл ажиллагаа;

2.1.4. “бүртгэлийн мэдүүлэг” гэж автотээврийн хэрэгслийн эзэмшигч, өмчлөгч нь батлагдсан загварын дагуу бүртгэлийн байгууллагад гарган өгч буй автотээврийн хэрэгсэл болон эзэмшигч, өмчлөгчийн мэдээлэл бүхий маягт;

2.1.5. “тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн сан” гэж Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 10.1.1-д заасан сан.

**ГУРАВ. Бүртгэл хөтлөх**

3.1. Бүртгэлийн байгууллага нь автотээврийн хэрэгсэл, өмчлөх, эзэмших ашиглах болон ашиглалттай холбоотой бүртгэлийг энэхүү журамд заасан бүртгэлийн мэдүүлэг болон хууль тогтоомжид заасан бусад нотлох баримтыг үндэслэн энэхүү журмын дагуу бүртгэл хөтөлнө.

3.2. Автотээврийн хэрэгслийн бүртгэл нь дараах төрөлтэй байна:

- 3.2.1. шинээр бүртгэх;
- 3.2.2. өмчлөгч, эзэмшигчийн;
- 3.2.3. түр дугаар олгох;
- 3.2.4. бүртгэлээс хасах;
- 3.2.5. техникийн өөрчлөлт;

### 3.2.6. нөхөн олголт.

3.3. Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санд дараах мэдээллийг бүртгэнэ:

#### 3.3.1. Өмчлөгч, эзэмшигчийн мэдээлэл:

- 3.3.1.1. Өмчлөгч, хамтран өмчлөгч, эзэмшигчийн нэр;
- 3.3.1.2. регистрийн дугаар;
- 3.3.1.3. оршин суугаа хаяг;
- 3.3.1.4. утасны дугаар, цахим хаяг.

#### 3.3.2. Тээврийн хэрэгслийн техникийн мэдээлэл:

- 3.3.2.1. Марк;
- 3.3.2.2. Модель;
- 3.3.2.3. Зориулалт;
- 3.3.2.4. Өнгө;
- 3.3.2.5. Хөдөлгүүрийн багтаамж /см<sup>3</sup>/;
- 3.3.2.6. Хөдөлгүүрийн тэжээлийн төрөл;
- 3.3.2.7. Жолооны хүрдний байрлал;
- 3.3.2.8. Даац/кг/;
- 3.3.2.9. Суудлын тоо;
- 3.3.2.10. Тэнхлэгийн тоо.

3.4. Автоматээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөхдөө дараах дарааллыг баримтална:

3.4.1. энэхүү журмын 2.1.4-д заасан бүртгэлийн мэдүүлэг болон бусад дагалдах нотлох баримтын хамт хүлээн авч иж бүрдэл, мэдээллийн үнэн зөв байдлыг хянана;

3.4.2. бүрдүүлэх нотлох баримт бүрэн бус, мэдээлэл зөрүүтэй бол бүртгэлд бүртгэхээс татгалzan эзэмшигч, өмчлөгчид мэдэгдэнэ;

3.4.3. бүртгэлийн мэдүүлэг, нотлох баримт шаардлага хангаж байгаа бол мэдээллийг тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санд/цаашид Мэдээллийн сан гэх/ үнэн зөв оруулна;

3.4.4. бүртгэсэн автомашиний хэрэгслийн бүртгэлийн мэдүүлэг болон дагалдах нотлох баримтыг цаасаар болон цахим архив үүсгэн архивын журмын дагуу баяжилт, бүртгэл хийн хадгална.

3.5. Автоматээврийн хэрэгслийг бүртгүүлэхдээ зөвхөн тухай автомашиний хэрэгслийг өмчлөгч, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгч, эзэмшигч өөрийн биеэр болон цахим, гарын үсгийг үндэслэн бүртгэнэ.

3.6. "Автоматээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг.2-р хэсэг: Ерөнхий шаардлага" MNS 4410-2:2017 стандартын 4-р бүлэгт заасан ангиллын дагуу улсын дугаарыг тухайн автомашиний хэрэгсэлд олгоно.

3.7. Бүртгэлд бүртгэж анх олгосон улсын дугаарыг ахин өөрчлөхгүй бөгөөд тухайн автомашиний хэрэгсэл ашиглалтаас хасагдсанаас хойш 3 сарын дараа уг улсын дугаарыг дахин олгож болно.

3.8.Үйлчилгээний хураамжийг бүртгэлийн байгууллага тогтооно.

3.9.Энэхүү журмын хавсралтаар батлагдсан нотлох баримтууд нь батлагдсан загвар, нууцлал, мэдээллийг агуулсан байна.

3.10. Дараах тохиолдолд автотээврийн хэрэгслийг бүртгэхийг хориглоно:

3.10.1.Монгол Улсад ашиглахыг хориглосон тээврийн хэрэгсэл;

3.10.2.бүртгэлийн мэдүүлэг болон нотлох баримт нь бүрэн бус, мэдээлэл зөрүүтэй, засварласан, нотлох баримтыг хуурамчаар үйлдсэн;

3.10.3.техникийн хяналтын үзлэгт тэнцээгүй, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд даатгуулаагүй;

3.10.4.зохих байгууллагын зөвшөөрөлгүй зориулалтыг өөрчилсөн;

3.10.5.хуулиар эрх олгогдсон эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас эзэмших, өмчлөх эрхэд хориглолт, хязгаарлалт хийсэн тухайн тээврийн хэрэгслийг;

3.10.6.өмчлөгч, эзэмшигч, мөн итгэмжлэгдсэн төлөөлөгч өөрийн биеэр ирээгүй;

3.10.7.тэмдэгтийн болон үйлчилгээний хураамж төлөөгүй.

3.11. Улсын дугаарын нэг серийг бүрэн олгож дууссаны дараа Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр дараагийн серийн дугаарыг олгоно.

### **Дөрөв. Бүртгэлийн байгууллага, улсын бүртгэгчийн эрх, үүрэг**

4.1.Бүртгэлийн байгууллага нь энэхүү журмын 3.2-т заасан бүртгэл хөтлөхийн зэрэгцээ бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээ, тайлан гаргах, эзэмшигч, өмчлөгч болон техникийн ашиглалттай холбоотой лавлагаа, мэдээлэл өгөх үйл ажиллагааг гүйцэтгэнэ.

4.2.Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, мэдээллийн санд мэдээлэл оруулахыг бүртгэлийн байгууллагын даргын томилсон улсын бүртгэгч гүйцэтгэнэ.

4.3.Улсын бүртгэгч нь автотээврийн болон эрх зүйн чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн, Иргэний хууль болон эд хөрөнгө бүртгэлийн талаар зохих сургалтад хамрагдсан байна.

4.4.Улсын бүртгэгч нь хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэх ба өөрийн хүлээн авч бүртгэл хөтөлсөн бүртгэлийн мэдүүлэг, нотлох баримт, тээврийн хэрэгслийн гэрчилгээнд дарж баталгаажуулна.

4.5.Улсын бүртгэгч нь бүртгэлийн мэдүүлэг, нотлох баримтын бүрдэл, түүний үнэн зөв байдлыг хянан үзэж шаардлага хангасан тохиолдолд бүртгэн авах ба энэхүү журмын 3.7-д заасан нөхцөлөөс бусад нөхцөлөөс бүртгэн авахыг татгалзахгүй байх, өөрийн гүйцэтгэсэн бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой үнэн зөв мэдээллийг хуулийн өмнө хариуцна.

## **Тав. Шинээр бүртгэх бүртгэл**

5.1. Шинээр бүртгэх бүртгэлд импортоор оруулж ирсэн болон Монгол Улсад үйлдвэрлэсэн автотээврийн хэрэгслийг мэдээллийн санд анх удаа бүртгэн мэдээлэл оруулах үйл ажиллагаа хамаарна.

5.2. Шинээр бүртгэсэн автотээврийн хэрэгслийг бүртгэн улсын дугаар, тээврийн хэрэгслийн гэрчилгээ олгоно.

5.3. Автотээврийн хэрэгслийг шинээр бүртгэхэд дараах нотлох баримт бичгийг үндэслэн бүртгэнэ:

5.3.1. үнэн зөв мэдүүлсэн бүртгэлийн мэдүүлэг, нотариатаар гэрчлүүлсэн худалдах, худалдан авсан гэрээ, иргэн бол иргэний үнэмлэх, аж ахуйн нэгж, байгууллага бол улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар шилжүүлсэн, болон бүртгэлд бүртгүүлэхийг хүссэн албан бичиг;

5.3.2. импортоор оруулж ирсэн шинэ автотээврийн хэрэгслийн хувьд техникийн паспорт, үйлдвэрлэгчийн дагалдах бичиг;

5.3.3. ашиглагдаж байгаад импортоор оруулж ирсэн автотээврийн хэрэгслийн гэрчилгээ, техникийн паспорт, үйлдвэрлэгчийн дагалдах бичиг тухайн улсын эрх бүхий байгууллагаас техникийн шаардлага хангаж байгааг тодорхойлсон дүгнэлт, үнэлгээний баримт бичиг, бүртгэлээс хассан тухай тодорхойлолт, тэмдэглэл;

5.3.4. гаалийн бүрдүүлэлтийн баримт, түр дугаар, техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт, жолоочийн хариуцлагын даатгалд даатгуулсан баримт;

5.3.5. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан тэмдэгтийн хураамж, үйлчилгээний төлбөр, авто тээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэ төлсөн баримт;

5.3.6. тусгай тоноглол суурилагдсан тээврийн хэрэгслийн хувьд нэмэлт төхөөрөмжийн техникийн байдлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар шалгуулж баталгаажуулсан дүгнэлт;

5.3.7. Монгол Улсад үйлдвэрлэсэн автотээврийн хэрэгслийн хувьд тохирлын гэрчилгээ, техникийн паспорт, авто тээврийн хэрэгслийн таних тэмдгийн дугаар олгосныг баталгаажуулсан баримт;

5.3.8. дипломат болон олон улсын байгууллагуудын тухайд энэ журмын 3.5-д зааснаас гадна гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын албан хүсэлт.

## **Зургаа. Өмчлөгч, эзэмшигчийн бүртгэл**

6.1. Өмчлөгч, эзэмшигчийн бүртгэлд тухайн автотээврийн хэрэгслийн өмчлөгч, хамтран өмчлөгч, эзэмшигч болон тэдгээрийн оршин суугаа хаягийн, мөн тухай автотээврийн хэрэгслийн барьцааны бүртгэл хамаарна.

6.2. Өмчлөгч, эзэмшигчийн бүртгэл хөтлөхдөө Иргэний хуульд заасан өмчлөх,

эзэмших эрх, түүнтэй холбоотой хэлцэл, хэлцлийн хугацаа зэргийг нотлох баримтад үндэслэн хянана.

6.3. Автотээврийн хэрэгслийн барьцааны бүртгэлийг бүртгэхдээ Иргэний хуулийн 13 дугаар бүлгийн нэг, хоёрдугаар дэд бүлгийг баримтлан бүртгэнэ.

6.4. Өмчлөгчөөс олгосон эрх, түүний ирүүлсэн хүсэлтийн дагуу тухайн автотээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчийг аль алиныг нь хамт бүртгэнэ.

6.5. Автотээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчийг бүртгэхдээ дараах нотлох баримтыг үндэслэн бүртгэнэ:

6.5.1. нотариатаар гэрчлүүлсэн худалдах, худалдан авах гэрээ, автотээврийн хэрэгслийг шилжүүлсэн болон шилжүүлэн авч буй өмчлөгч, хамтран өмчлөгч, эзэмшигчийн мэдүүлсэн бүртгэлийн мэдүүлэг, аж ахуйн нэгж байгууллагын албан бичиг, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

6.5.2. шилжүүлэн авч байгаа өмчлөгч, хамтран өмчлөгч, эзэмшигчийн иргэний үнэмлэх, нотариатаар гэрчлүүлсэн худалдах, худалдан авсан гэрээ;

6.5.3. автотээврийн хэрэгслийн гэрчилгээ;

6.5.4. жолоочийн хариуцлагын даатгалд даатгуулсан баримт;

6.5.5. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан тэмдэгтийн хураамж, үйлчилгээний төлбөр, авто тээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэ төлсөн баримт;

6.5.6. автотээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч иргэн нас барсан тохиолдолд өв залгамжлалын гэрчилгээ;

6.5.7. Улсын бүртгэлээс хасагдсан хуулийн этгээдийн тухайд татан буугдсан хуулийн этгээдийн үүсгэн байгууллагчдын хүсэлт, улсын бүртгэлийн байгууллагын тодорхойлолт.

### **Долоо. Түр дугаар олгох бүртгэл**

7.1. Түр дугаарын бүртгэлд импортоор орж ирээд улсын дугаар авах хүртэлх бүртгэл хамаарна.

7.2. Монгол Улсад импортоор орж ирж буй бүх автотээврийн хэрэгслийг гаалийн бүрдүүлэлтийн баримт бичгийг үндэслэн түр дугаар олгоно.

7.3. Түр дугаараар зөвхөн гаалиас үзэсгэлэн, худалдааны талбай, агуулах, эзэмшигчийн оршин суугаа газар хүрэх болон техникийн хяналтын үзлэгт орох, бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх, үзэсгэлэн худалдаанд оролцох зэрэгт л замын хөдөлгөөнд түр оролцохыг зөвшөөрнө.

7.4. Түр дугаарыг 6 сар хүртэл хугацаагаар олгох бөгөөд шаардлагатай тохиолдолд дахин 3 сар хүртэл сунгаж болно.

### **Найм. Бүртгэлээс хасах бүртгэл**

8.1. Бүртгэлээс хасах бүртгэлд ашиглалтаас хасагдаж буй болон Монгол Улсад ашиглагдаж байгаад экспортод гарч буй автотээврийн хэрэгслийн бүртгэл хамаарна.

8.2. Бүртгэлээс хасах бүртгэл хөтлөхдөө дараах нотлох баримтыг үндэслэн бүртгэнэ:

8.2.1. иргэний өргөдөл, аж ахуйн нэгж байгууллагын албан хүсэлт, бүртгэлийн мэдүүлэг;

8.2.2. автотээврийн хэрэгслийн тээврийн хэрэгслийн гэрчилгээ, улсын дугаарын тэмдэг, хэрэв хаяж үрэгдүүлсэн бол олон нийтийн мэдээллээр зарлуулсан тодорхойлолт;

8.2.3. үйлчилгээний хураамж төлсөн баримт;

8.2.4. ашиглалтаас хасах тохиолдолд дахин боловсруулах үйлдвэрийн тодорхойлолт.

8.2.5. Улсын бүртгэгч энэхүү журмын 8.2-д заасан бүртгэлийн мэдүүлэг, нотлох баримтыг үндэслэн тээврийн хэрэгслийн гэрчилгээ улсын дугаарын тэмдгийг хураан авч, тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн сан, автотээврийн хэрэгслийн гэрчилгээнд улсын бүртгэлээс хассан тухай тэмдэглэлийг хийж, тодорхойлолтыг өмчлөгчид олгоно.

### **Ес. Техникийн өөрчлөлтийн бүртгэл**

9.1. Техникийн өөрчлөлтийн бүртгэлд автотээврийн хэрэгслийн зориулалт, өнгө өөрчлөх, нэмэлт тоног төхөөрөмжөөр тоноглосныг бүртгэх, нийтийн тээврийн үйлчилгээнд ашиглахтай холбоотой бүртгэл хамаарна.

9.2. Техникийн өөрчлөлтийн бүртгэлийг дараах нотлох баримтыг үндэслэн бүртгэнэ:

9.2.1. өмчлөгчийн хүсэлт, бүртгэлийн мэдүүлэг;

9.2.2. техникийн өөрчлөлт нь стандартын шаардлага хангаж байгааг нотолсон техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт;

9.2.3. нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн хувьд тээвэр зохицуулах эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

9.2.4. арал, бүхээг өөрчлөгдсөн бол гаалийн бүрдүүлэлт хийснийг нотлох мэдүүлэг, баримт, бүртгэлээс хассан тухай тодорхойлолт;

9.2.5. зориулалт өөрчилсөн бол үйлдвэрлэгчийн дүгнэлт;

9.2.6. улсын тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамж, автотээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэ төлсөн баримт.

9.3. Нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгсэл үйлчилгээнээс хасагдсан тохиолдолд тухайн дугаарын сери, дугаар өөрчлөгдөхгүйгээр автомашины энгийн дугаар олгоно.

## **Арав. Нөхөн олголтын бүртгэл**

10.1. Нөхөн олголтын бүртгэлд автотээврийн хэрэгслийн улсын дугаарын тэмдэг, тээврийн хэрэгслийн гэрчилгээг нөхөн олгох бүртгэл хамаарна.

10.2. Нөхөн олголтын бүртгэлийг дараах нотлох баримтыг үндэслэн бүртгэнэ:

10.2.1. өмчлөгчийн хүсэлт, бүртгэлийн мэдүүлэг;

10.2.2. автотээврийн хэрэгслийн гэрчилгээний үнэ, улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт;

10.2.3. улсын дугаарын тэмдэг нөхөн олгосон тухай тэмдэглэгээг бүртгэлийн санд бүртгэнэ.

## **Арван нэг. Цахим үйлчилгээ**

11.1. Тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн цахим санг бүрдүүлэх, ашиглахдаа Засгийн газрын 2017 оны 159 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн цахим мэдээллийн санг бүрдүүлэх, ашиглах журам”-ыг мөрдлөг болгоно.

11.2. Тээврийн хэрэгслийн бүртгэлийн сан нь Улсын бүртгэлийн сан, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын сан, техникийн хяналтын үзлэгийн сан, гаалийн мэдээллийн сан зэрэг цахим сангуудтай холбогдон мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлсэн байна.

11.3. Бүртгэлийн дараах үйлчилгээг цахимаар авах боломжийг бүрдүүлсэн байна. Үүнд:

11.3.1. бүртгэлийн мэдүүлэг мэдүүлэх, хүлээн авах;

11.3.2. өмчлөгч, эзэмшигчийн бүртгэл, хаягийн өөрчлөлт;

11.3.3. автотээврийн хэрэгслийн гэрчилгээ нөхөн олгох;

11.3.4. өмчлөгч, эзэмшигчийн лавлагаа.

11.4. Бүртгэлийн цахим үйлчилгээ авах иргэн аж ахуйн нэгж байгууллага нь зохих журмын дагуу тоон гарын үсэг хэрэглэх гэрчилгээ авсан байна.

11.5. Иргэн, хуулийн этгээд нь өөрийн тоон гарын үсгийг ашиглан төрийн нэгдсэн үйлчилгээний порталаар дамжин цахим үйлчилгээг авна.

11.6. Цахимаар үйлчилгээ авахад энэхүү журамд заасан бүртгэлийн мэдүүлэг, шаардагдах нотлох баримтын иж бүрдлийг бүрэн хангасан байна.

11.7. Цахим үйлчилгээгээр автотээврийн хэрэгслийн гэрчилгээ шуудангаар хүргэн өгөх эсвэл угтах үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгчид хүргэнэ.

## **Арван хоёр. Тээврийн хэрэгслийн дугаарын үйлдвэрлэл**

12.1. Тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэгч/цаашид Үйлдвэрлэгч гэх/ нь зохих журмын дагуу авсан тусгай зөвшөөрлийн хүрээнд үйлдвэрлэл явуулна.

12.2. Үйлдвэрлэгч нь улсын дугаарын тэмдэг үйлдвэрлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмж, хүний нөөцөөр бүрэн хангагдсан, аюулгүй ажиллагааны

шаардлагыг хангасан ажлын байранд үйлдвэрлэлийг эрхэлнэ.

12.3. “Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг.2-р хэсэг: Ерөнхий шаардлага” MNS 4410-2:2017 стандартын 5 дугаар бүлэгт заасан үзүүлэлт шаардлагад нийцүүлэн үйлдвэрлэх бөгөөд энэхүү стандартад заагдсанаас өөр бэлдэц, тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэхийг хориглоно.

12.4. Бүртгэлийн байгууллага нь “Автотээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн дугаарын тэмдэг.2-р хэсэг: Ерөнхий шаардлага” MNS 4410-2:2017 стандартад нийцсэн улсын дугаарын тэмдгийн бэлдцээр тээврийн хэрэгслийн дугаар үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагуудыг ханган, үйлдвэрлэлд хяналт тавьж ажиллана.

12.5. Улсын дугаарын тэмдгийг тухайн дугаарын тэмдгийг үйлдвэрлэсэн байгууллага тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн санд оруулан автотээврийн хэрэгсэлд байрлуулан бэхэлж өгөх бөгөөд бүртгэлийн байгууллага лацадна.

### **Арван гурав. Бусад зүйл**

13.1. Автотээврийн хэрэгслийг бүртгэж, дугаар олгох, шилжилт, өөрчлөлт хийх, бүртгэлээс хасах, түр дугаар олгох үйл ажиллагаатай холбоотой санал, гомдлыг бүртгэлийн байгууллагад гаргах ба уг гомдолд 14 хоногийн дотор хариу өгнө.

13.2. Бүртгэлийн мэдүүлэг, нотлох баримтыг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдвол энэ тухай Цагдаагийн байгууллагад хандана.

--- оОо ---